

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Аудитын код: ЗАА-2024/06/НА-СТА-ОНА**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улиастай сум 2024 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: <a href="mailto:Bat-Undraa@audit.gov.mn">Bat-Undraa@audit.gov.mn</a> Аудитын менежер : Х.Болдбаатар Утас:99105506 Цахим хаяг: <a href="mailto:boldbaatarkh@audit.gov.mn">boldbaatarkh@audit.gov.mn</a> Аудитор : Г.Нармандах Утас:99031794 Цахим хаяг: <a href="mailto:narmandakhg@audit.gov.mn">narmandakhg@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл .....
- 4.2 Материаллаг байдал .....
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ТОСОН ОЧИРТ ХАЙРХАН  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Г.БАТЖАРГАЛ-Д

2024.03.12 № 224  
танай -ны № -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Богино хугацаатай өр төлбөр өмнөх оноос 100.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь үйл ажиллагаанд ашигладаг аж ахуйн материалын үнэ өссөн, татварын өр нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Аудитын гол асуудал**

Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар тайлант үеийн алдагдал нэмэгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ нь дулаан үйлдвэрлэлээр төсвийн 5 байгууллага, 5 айл өрхтэй, бохир ус татан зайлуулах арга хэмжээнд 12 айл өрх, 21 аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Audit(D)Дүгнэлт/2024

013020339

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгод түвшний гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

  
Д. БАТ-УНДРАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Балансын зүйл	Үндсэн код	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		9,591,989.75	4,113,291.44
Бүлэггүй		9,591,989.75	4,113,291.44
Касст байгаа бэлэн мөнгө	1001-1000	-	2,272,200.00
Хас банкны харилцах данс	1101-1000	9,366,510.71	1,841,091.44
Төрийн банкны харилцах данс	1102-1000	225,479.04	-
1.1.02 Дансны авлага		26,953,618.65	37,029,454.00
Бүлэггүй		26,953,618.65	37,029,454.00
Дансны авлага	1201-1000	26,953,618.65	37,029,454.00
1.1.03 Татвар, НДШ-ийн авлага		-	-
Бүлэггүй		-	-
НДШ-ийн авлага	1203-1000	-	-
1.1.04 Бусад авлага		-	209,397.73
Бүлэггүй		-	209,397.73
Ажиллагсдаас авах авлага	1204-1000	-	209,397.73
1.1.06 Бараа материал		96,451,089.37	49,360,993.20
Бүлэггүй		96,451,089.37	49,360,993.20
Түлш халаалтын материал	1401-1000	-	-
Хангамжийн материал	1402-0100	87,925,649.37	46,769,403.20
Бичиг хэргийн материал	1402-1000	773,780.00	1,285,030.00
Хөдөлмөр хамгааллын материал	1402-2000	4,618,060.00	530,560.00
Шатах тослох материал	1402-4000	2,629,700.00	776,000.00
Цэвэрлэгээний материал	1402-6000	503,900.00	-
1.1.07 Урьдчилж төлсөн зардал/тооцоо		661,800.00	729,722.56
Бүлэггүй		661,800.00	729,722.56
Цалингийн урьдчилгаа	1501-0200	661,800.00	729,722.56
1.2.01 Үндсэн хөрөнгө		3,981,597,728.06	3,743,355,427.85
Бүлэггүй		3,981,597,728.06	3,743,355,427.85
Барилга, байгууламж	2001-1000	1,095,850,545.75	1,095,850,545.75
Машин, тоног төхөөрөмж	2002-1000	4,324,652,454.00	4,341,352,454.00
Тээврийн хэрэгсэл	2002-2000	78,993,300.00	78,993,300.00
Тавилга, эд хогшил	2003-1000	3,976,263.62	3,976,263.62
Компьютер, дагалдах хэрэгсэл	2003-2000	7,180,082.00	7,180,082.00
Хур. элэгдэл -Барилга, байгууламж	2021-1000	107,390,342.79	130,069,590.03
Хур. элэгдэл -Машин, тоног төхөөрөмж	2022-1000	1,356,825,891.34	1,584,391,023.47
Хур. элэгдэл -Тээврийн хэрэгсэл	2022-2000	62,920,540.15	64,669,423.67
Хур. элэгдэл -Тавилга, эд хогшил	2023-1000	1,122,026.43	1,442,642.79
Хур. элэгдэл -Компьютер, дагалдах хэрэгсэл	2023-2000	796,116.60	3,424,537.56
1.2.02 Биет бус хөрөнгө		70,656,000.00	70,656,000.00
Бүлэггүй		70,656,000.00	70,656,000.00

Биет бус хөрөнгө	2101-1000	74,616,000.00	74,616,000.00
Хур. хорогдол -Биет бус хөрөнгө	2121-1000	3,960,000.00	3,960,000.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>4,185,912,225.83</b>	<b>3,905,454,286.78</b>
2.1.1.01 Дансны өглөг		29,541,429.18	41,325,407.27
Бүлэггүй		29,541,429.18	41,325,407.27
Дансны өглөг	3101-1000	29,541,429.18	41,325,407.27
2.1.1.02 Цалингийн өглөг		14,633,635.20	19,356,003.60
Бүлэггүй		14,633,635.20	19,356,003.60
Цалингийн өглөг	3301-1000	14,633,635.20	19,356,003.60
2.1.1.03 Татварын өр		22,959,847.90	112,064,925.37
Бүлэггүй		22,959,847.90	112,064,925.37
ХХОАТ-ын өглөг	3401-2000	10,996,796.25	34,867,628.20
Бусад татварын өглөг	3401-3000	-	42,362,990.05
НӨАТ-ын өглөг	3401-4000	11,963,051.65	34,834,307.12
2.1.1.04 НДШ - ийн өглөг		21,448,581.38	15,901,132.36
Бүлэггүй		21,448,581.38	15,901,132.36
НДШ-ийн өглөг	3402-1000	21,448,581.38	15,901,132.36
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр		-	-
Бүлэггүй		-	-
Ажиллагсад өгөх өглөг	3801-1000	-	-
2.3.01 Өмч: - төрийн		5,414,573,985.00	5,414,573,985.00
Бүлэггүй		5,414,573,985.00	5,414,573,985.00
Төрийн өмч	4101-0100	5,414,573,985.00	5,414,573,985.00
2.3.09.1 Тайлангийн үеийн ашиг		-	(305,045,052.55)
Бүлэггүй		-	(305,045,052.55)
Тайлант үеийн ашиг /алдагдал/	4601-0000	-	(305,045,052.55)
2.3.09.2 Өмнөх үеийн ашиг		(1,317,245,252.83)	(1,392,722,114.27)
Бүлэггүй		(1,317,245,252.83)	(1,392,722,114.27)
Хуримтлагдсан ашиг алдагдал	4601-0100	(1,317,245,252.83)	(1,392,722,114.27)
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>4,185,912,225.83</b>	<b>3,905,454,286.78</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	603,287,117.79	787,827,010.65
02	Борлуулалтын өртөг	799,414,326.45	949,775,457.06
03	Нийт ашиг( алдагдал)	(196,127,208.66)	(161,948,446.41)
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	0.00	0.00
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	86,250.00	42,529,090.91
08.1	Орлогын дүн	86,250.00	42,529,090.91
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	112,288,462.10	119,147,819.83

11	Санхүүгийн зардал	0.00	8,998,795.38
12	Бусад зардал	105,300.00	57,479,081.84
12.1	Зардлын дүн	112,393,762.10	185,625,697.05
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(71,718.75)	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг ( алдагдал)	0.00	0.00
17.1	Олз, гарзын дүн	(71,718.75)	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	(308,506,439.51)	(305,045,052.55)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(308,506,439.51)	(305,045,052.55)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	(308,506,439.51)	(305,045,052.55)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,343,917,985.00	0.00	0.00	(1,012,376,416.80)	4,331,541,568.20
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	3,637,603.48	3,637,603.48
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(308,506,439.51)	(308,506,439.51)

05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	70,656,000.00	0.00	0.00	0.00	70,656,000.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,414,573,985.00	0.00	0.00	(1,317,245,252.83)	4,097,328,732.17
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	(75,476,861.44)	(75,476,861.44)
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(305,045,052.55)	(305,045,052.55)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	5,414,573,985.00	0.00	0.00	(1,697,767,166.82)	3,716,806,818.18

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгийн дотоод гүйлгээ	0.00	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	680,961,409.30	761,233,094.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	668,300,409.30	732,186,108.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	55,086.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00

1.1.6	Бусад мөнгөн орлого	12,661,000.00	28,991,900.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	683,706,931.57	766,711,792.31
1.2.1	Ажиллагчдад төлсөн	203,627,021.93	250,208,509.56
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	52,772,944.92	89,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	189,256,776.80	143,344,402.50
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	94,847,280.21	93,237,616.64
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	84,944,843.00	121,267,577.50
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	40,428,164.71	54,939,726.09
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	17,829,900.00	14,713,960.02
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,745,522.27)	(5,478,698.31)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,745,522.27)	(5,478,698.31)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,337,512.02	9,591,989.75
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,591,989.75	4,113,291.44

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ нь Тосонцэнгэл сумын ард иргэдийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр ус, дулаанаар найдвартай хангаж, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, стандартын дагуу цэвэрлэж байгальд нийлүүлэх зорилго тавин ажиллаж байна.

#### 3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ нь Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, бусад хууль, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, Салбарын сайдуудын хамтарсан тушаал шийдвэрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 280.4 сая төгрөгөөр буюу 6.7 хувиар буурсан байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,592.0	4113.3	-5478.69
Авлага	26,953.6	37,029.45	10,075.83
Бараа материал	96,451.1	49,360.99	-47,090.09
Үндсэн хөрөнгө	4,056,213.7	3,814,011.42	-238,242.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,189,872.3</b>	<b>3,905,454.28</b>	<b>-280,457.93</b>
Өр төлбөр	88,583.5	188,647.46	100,063.97
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,097,328.7	3,716,809.81	-380,521.91
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,189,872.3</b>	<b>3,905,454.28</b>	<b>-280,457.93</b>

Авлага 10.07 сая төгрөгөөр өссөн нь сум дундын нэгдсэн эмнэлгийн халаалт, усны зардал гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас дараа сард орж ирдэг учир авлага ондоо багтаж төлөгдөөгүй.

Бараа материалын данс 47.09 сая төгрөгөөр буурсан нь өвөлжилтийн бэлтгэл ажил, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхээр бэлтгэсэн бараа материалын үлдэгдэл 2023 оны 2 сард гарсан цэвэр усны шугамын гэмтэл болон 4 сард гарсан дулааны шугамын гэмтэлд хэрэглэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 238.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн хэмжээгээр буурчээ.

Өглөг дансны үлдэгдэл өмнөх оноос 100,0 сая төгрөгөөр өссөн нь үйл ажиллагаанд ашигладаг аж ахуйн материалын үнэ өссөн, үйл ажиллагаанд гарсан томоохон гэмтэлтэй холбоотой нөөц материал ашиглагдаж дахин нөөц бүрдүүлэх болон татварын хяналт шалгалтаар үл хөдлөх, үйлдвэрлэлийн зориулалттай ус ашигласан төлбөр болон НӨАТ-н тайлангийн алдаа зэргээс татварын ногдол, алданги, торгууль тавиулсантай холбоотой байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2023 оны төлөвлөгөө /мян.төг/
---	----------	-------------------------------

		Байгууллагын нийт дүн	Дулаан хангамжийн хэсэг	Цэвэр усан хангамжийн хэсэг	ЦБ, бохир ус татан зайлуулах хэсэг
<b>1</b>	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>673,650.00</b>	<b>588,880.00</b>	<b>52,140.00</b>	<b>32,630.00</b>
1.1.	<b>Цэвэр бохир усны орлогын дүн</b>	<b>78,200.00</b>	-	<b>47,570.00</b>	<b>30,630.00</b>
1.1.1.	ААНБ-н хэрэглэгч	71,700.00		43,020.00	28,680.00
1.1.2.	Ахуйн хэрэглэгч/айл өрх/	6,500.00		4,550.00	1,950.00
1.2.	<b>Дулаан хангамжийн орлогын дүн</b>	<b>588,880.00</b>	<b>588,880.00</b>	-	-
1.2.1	ААНБ-н хэрэглэгч	587,600.00	587,600.00		
1.2.2	Ахуйн хэрэглэгч/айл өрх/	1,280.00	1,280.00		
1.3.	<b>Суурь хураамжийн орлого</b>	<b>1,570.00</b>	-	<b>1,570.00</b>	-
1.3.1	ААНБ-н хэрэглэгч	1,250.00		1,250.00	
1.3.2	Ахуйн хэрэглэгч/айл өрх/	320.00		320.00	
1.4.	<b>Үйл ажиллагааны бусад орлогын дүн</b>	<b>5,000.00</b>	-	<b>3,000.00</b>	<b>2,000.00</b>
1.4.1	Засвар үйлчилгээний орлого	5,000.00		3,000.00	2,000.00
1.4.2	Бусад орлого	-	-	-	-
1.4.4	Орон нутгийн татаас / төсөв/ орлого	-	-	-	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>682,636.00</b>	<b>281,001.00</b>	<b>255,458.00</b>	<b>126,177.00</b>
2.1.	Цалин хөлс	310,900.00	118,300.00	136,700.00	55,900.00
2.2.	Татвар нийгмийн даатгалын зардал	121,900.00	45,500.00	42,700.00	13,700.00
2.3.	Ашиглалтын зардал	127,000.00	70,000.00	25,800.00	31,200.00
2.4.	Хангамж бараа материалын зардал	26,500.00	10,130.00	11,600.00	4,770.00
2.5.	Урсгал засвар, үйлчилгээний зардал	28,200.00	8,330.00	11,200.00	8,670.00
2.6.	Лаборатори шинжилгээний зардал	1,800.00		900.00	900.00
2.7	Хөдөлмөр хамгааллын зардал	7,600.00	2,900.00	3,300.00	1,400.00
2.8	Хөрөнгө оруулалтын зардал	44,000.00	17,100.00	19,000.00	7,900.00
2.9	Эрсдлийн сангийн зардал	6,736.00	2,561.00	2,963.00	1,212.00

2.10	Томилолтын зардал	1,000.00	1,000.00	-	-
2.11	Сургалтын зардал	3,500.00	3,500.00	-	-
2.12	Ажиллагсдын нийгмийн зардал	3,500.00	1,680.00	1,295.00	525.00
2.13	Элэгдлийн зардал	255,400.00	82,398.00	72,424.80	109,177.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ АЛДАГДАЛ</b>	<b>(8,986.00)</b>	<b>307,879.00</b>	<b>(203,318.00)</b>	<b>(93,547.00)</b>

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ 2023 онд хуралдаагүй тул гүйцэтгэх захирлаар батлуулсан байна.

2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 673,6 сая төгрөгөөр, нийт зардлыг 682,6 сая төгрөгөөр, 8,9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 44,0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 787 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,135.4 сая төгрөгийн зардал гарган, 305 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 787 сая төгрөг болж төлөвлөснөөс 114,2 сая төгрөг буюу 16,4 хувиар өссөн нь дулаан хангамжийн үнэ тариф өссөн болон 1, 2-р сургуулиуд усны төлбөрөө төсөвт тодорхой хэмжээгээр суулгаж төлж эхэлсэнтэй холбоотой.

Нийт зардлын гүйцэтгэл 1,135.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 452,7 сая төгрөгийн илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өссөн, цахилгааны тариф өссөн, нүүрсний үнэ өссөн, хангамжийн бараа материалын зардал өссөн болон тайлант онд үйл ажиллагаанд хоёр томоохон гэмтэл гарсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг алдагдал -305 сая төгрөг болж, төлөвлөснөөс 296,1 саяар алдагдал өссөн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ОНӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Нармандах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаа Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 1,135.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 17.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1 зөвлөмж 1 төлбөрийн акт хүргүүлсэн байна.

Төсвөөс нягтлан бодогчийн 1.232.0 мянган төгрөгийн магистрын сургалтын төлбөрийг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 41 дүгээр зүйлийн 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах гэж заасныг тус тус зөрчсөнд төлбөрийн акт тогтоосон.

Тээвэр шатахууны зарцуулахдаа Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын автомашины 100 км-т зарцуулах норм нормативын дагуу тооцоолол хийж, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, анхан шатны баримтын бүрдлийг сайжруулах, Ажил гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, Шилэн дансны цахим мэдээллийн санд холбогдох мэдээллийг тухай бүр бүрэн гүйцэд хуулийн хугацаанд нь байршуулж хэвших зөвлөмж өгсөн.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,232.0	1	1,232.0	100
Албан шаардлага					
Зөвлөмж	1	594,143.0	1	594,143.0	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>595,375.0</b>		<b>595,375.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Богино хугацаат өр төлбөр, тайлант үеийн алдагдлыг бууруулах шаардлагатай байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

**5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт өгөөгүй

**5.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага өгөөгүй

**5.3 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн								

БОЛОВСРУУЛСАН : АУДИТОР

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Г.НАРМАНДАХ

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР